



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2025/01/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Дундговь аймаг  
2025 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох  
Утас: 70592439  
Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ  
Утас: 70592225  
Цахим хаяг: [Oyun-erdenet@audit.gov.mn](mailto:Oyun-erdenet@audit.gov.mn)

Ахлах аудитор: Т.Батсайхан  
Утас: 70593113  
Цахим хаяг: [Batsaikhant@audit.gov.mn](mailto:Batsaikhant@audit.gov.mn)

Аудитор: Ж.Угтахбаяр  
Утас: 70593113  
Цахим хаяг: [Ugtakhbayarj@audit.gov.mn](mailto:Ugtakhbayarj@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

.....	0
1.Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	6
3. Аудитын илрүүлэлт .....	6
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

## 1.Аудитын санал дүгнэлт



### ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

### ДУНДГОВЬ АЙМГИЙН АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА Ж.БАТХӨЛӨГ ТАНАА

2025.03.19

№

79

танай

-ны №

-т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг харууцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн эхний үлдэгдэл 2023 оны аудитлагдсан санхүүгийн нэгтгэсэн тайлангаас 18.9 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь ахмадын сангийн үлдэгдэл, улсын төсвийн байгууллагын төвлөрүүлсэн дүнг устгал хийсэнтэй холбоотой байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

#### Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Орон нутгийн хөгжлийн сан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ сангийн хөрөнгийг зураг төсөвгүй, эдийн засгийн тооцоо судалгаагүй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдээгүй төсөл, арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж баталсан, Хоршоо хөгжүүлэх сангийн тайлант онд төлөх үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй зэрэг зөрчлүүд нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар эрсдэл өндөр үнэлэгдсэн асуудал байлаа.

#### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний

4825020270

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилт, 98 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 84.4 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	955,469.1	959,507.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	502,471.5	516,512.0
33	АВЛАГА	252,912.2	208,262.7
35	БАРАА МАТЕРИАЛ	200,085.4	234,733.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,614,624.8	1,890,555.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,614,624.8	1,890,555.7
39200	Биет хөрөнгө	1,593,556.0	1,870,601.6
39300	Биет бус хөрөнгө	21,068.7	19,954.1
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,570,093.9</b>	<b>2,850,063.5</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	14,925.0	40,103.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,925.0	40,103.4
41300	Өглөг	14,925.0	40,103.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,555,168.9	2,809,960.1
51	Засгийн газрын хувь оролцоо	2,555,168.9	2,809,960.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	608,503.9	608,503.9
51200	Хуримтлагдсан үр дүн	1,527,731.6	1,782,522.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	418,933.4	418,933.4
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,570,093.9</b>	<b>2,850,063.5</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,601,457.5	2,632,878.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	391,602.6	556,229.8
110	Орлогын албан татвар	175,847.1	434,306.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	175,847.1	434,306.1
113	Хөрөнгийн албан татвар	68,268.6	78,978.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	147,486.8	42,944.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	224,355.9	843,487.6
120	Нийтлэг татварын бус орлого	224,355.9	843,487.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	985,499.0	1,233,161.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,174,692.6	1,703,674.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,174,692.6	1,703,674.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,150,271.8	1,597,364.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	363,676.4	576,708.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,535.6	70,475.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,261.2	266,300.5
2104	Хангамж, бараа материалын зардал	67,904.3	63,880.9
2105	Нормативт зардал	0.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,550.6	90,060.8
2107	Томилолт, зочны зардал	17,683.0	18,472.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	227,366.0	30,956.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	377,294.8	480,510.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,420.8	106,309.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	426,764.9	929,204.9
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	235,382.3	674,413.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	235,382.3	254,791.2

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,325,648.2	2,325,648.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-5,861.5	-5,861.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,319,786.6	2,319,786.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	235,382.3	235,382.3
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,555,168.9	2,555,168.9
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,555,168.9	2,555,168.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,555,168.9	2,555,168.9
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	254,791.2	254,791.2
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,809,960.1	2,809,960.1

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,568,727.5	1,951,355.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	391,602.6	556,229.8
110	Орлогын албан татвар	175,847.1	434,306.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	175,847.1	434,306.1
113	Хөрөнгийн албан татвар	68,268.6	78,978.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	147,486.8	42,944.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	20,701.1	19,308.5
1181	Газрын төлбөр	16,914.7	23,636.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	109,871.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	191,625.9	161,964.3
120	Нийтлэг татварын бус орлого	191,625.9	161,964.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	985,499.0	1,233,161.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	963,496.4	1,448,535.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	963,496.4	1,448,535.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	939,075.6	1,342,225.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	364,761.5	576,502.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,582.0	70,428.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,261.2	266,300.5
2104	Хангамж, бараа материалын зардал	48,103.4	62,942.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,835.6	81,616.2
2107	Томилолт, зочны зардал	17,683.0	18,472.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	227,366.0	30,956.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	179,482.9	235,007.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,420.8	106,309.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	605,231.1	502,820.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	443,151.4	488,779.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	443,151.4	488,779.9
2200	Дотоод эх үүсвэрээр	443,151.4	488,779.9
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(443,151.4)	(488,779.9)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(127,800.0)	0.0

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	127,800.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	34,279.7	14,040.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	468,191.8	502,471.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	502,471.5	516,512.0

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,309,640.4	1,835,768.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,518,145.0	1,351,951.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,450,900.1	1,285,474.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	608,178.7	576,501.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,942.1	70,428.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	268,526.7	266,300.5
2104	Хангамж, бараа материалын зардал	52,159.8	51,378.5
2105	Нормативт зардал	0	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	86,762.9	86,579.1
2107	Томилолт, зочны зардал	19,106.0	18,472.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,421.5	4,880.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	329,802.4	210,933.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,244.9	66,476.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,244.9	66,476.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	696,495.4	483,816.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	95,000.0	0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,309,640.4	1,903,623.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	373,707.8	358,759.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,462,445.0	1,392,764.8
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0
34	ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	473,487.60	152,098.55
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		299,821.3
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		367,676.1

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	96,176.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	96,176.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	56,343.8
2104	Хангамж, бараа материалын зардал	11,563.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,076.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,704.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,832.9
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,832.9
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	96,176.7
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	96,176.7

## 3. Аудитын илрүүлэлт

### 3.1 Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй. Харин Мал хамгаалах сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 224,223.6 мянган

төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 189,892.5 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 34,331.1 мянган төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

**3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шүүд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 4 сан түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

*Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:*

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нуггийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	<b>НИЙТ</b>	6	1	5		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 643,852.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 204,707.4 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 4,698.3 мянган төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 255,331.1 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага, 179,115.8 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 68.2 хувийг залруулагдаагүй, 31.8 хувийг залруулсан алдаа эзэлж байна.

Нийт 439,145.3 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчлийн 50.3 хувь буюу 221,000.0 мянган төгрөг нь нийцлийн аудитын асуудал, үлдсэн 49.7 хувь буюу 218,145.3 мянган төгрөг нь санхүүгийн тайлангийн аудитын зөрчил илэрчээ. Дээрх завсрын аудитаар илэрсэн зөрчлүүдийг жилийн эцсийн санхүүгийн тайланд хэрэгжүүлж, хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Харин санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 26,696.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 1,403.3 мянган төгрөгөөр буюу 5.3 хувиар бага байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

